



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/17

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх “Баруун чиглэлийн авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам” 7.1 км (Төв)-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Г.Сурмаа - Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Я.Пагамаажав - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Эрдэнэчимэг - Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Д.Дашдаваа - Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. “Баруун чиглэлийн авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам” 7.1 км (Төв)-ийн гүйцэтгэгчийг сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Сурмаа)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнт танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Д. Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. МӨНХБААТАР

• 4122010058